



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 16246

Улаанбаатар хот

“Шинэ оны анхны нар угтах” ёслолын  
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.5 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүрэгт “Шинэ оны анхны нар угтах” ёслолын үйл ажиллагааг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулсугай.

2. Ёслолын арга хэмжээг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. “Шинэ оны анхны нар угтах” арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулж, олон нийтийн оролцоог ханган, төлөвлөгөө боловсруулан хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг (Л.Санжийжамц)-т даалгасугай.

4. Үйл ажиллагаанд зарцуулагдах 2,259,800 (Хоёр сая хоёр зуу тавин есэн мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 12 сарын 12-ны өдрийн 12/12 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн  
ахлагч:  
Гишүүд:

Л.Санжийжамц	Засаг даргын Тамгын газрын дарга
Б.Отгонжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Ц.Мягмарсүрэн	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Д.Хүрэлбаатар	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Ш.Бат-Өлзий	Цэргийн штабын дарга
П.Дэлгэр	Аж ахуйн тасгийн дарга
Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
Т.Лхагвасүрэн	Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа
Б.Цогбадрах	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа
Б.Гэрэлмаа	Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын захирал
Ч.Батхуяг	Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын захирал
Д.Гантулга	Илч-Орд тохижилт ОНӨААТҮГ-ын захирал
Б.Алтанцоож	Соёлын ордны захирал
М.Өсөхдэлгэр	Багахангай Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвийн захир
Э.Юмжирмаа	Хөдөө аж ахуйн тасгийн дарга

Нарийн бичгийн  
дарга:

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 12 сарын 18-ны өдрийн 100 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



НАР ХАРАХ ЁСЛОЛЫН АРГАХ ХЭМЖЭЭНД АЖИЛД  
ЗАРЦУУЛАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Үнэ
1	Түлш	л	210	3,890	816,900
2	Ажлын хэсгийн хяналтын шатахуун	л	14	2,410	337,400
3	Түүдэгний мод	м <sup>3</sup>	2	90,000	180,000
4	Анонс	м <sup>2</sup>	9	25,000	225,000
5	Аарц	кг	10	6,000	60,000
6	Чацаргана	кг	10	5,500	55,000
7	Элсэн чихэр	кг	3	3,500	10,500
8	Чихэр	кг	3	25,000	75,000
9	Гурил	кг	7	2,500	17,500
10	Нэг удаагийн аяга	Б	10	7,000	70,000
11	Ааруул	кг	3	30,000	90,000
12	Цайны хийц	ш	5	2,500	12,500
13	Мах	кг	5	12,000	60,000
14	Тос	л	5	8,000	40,000
15	Газ	цэнэглэх	1	70000	70,000
16	Мод	ш	20	7000	140,000
<b>НИЙТ</b>					2,259,800